



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2021.08.07 № 6-1/5042
танай _____-ны № _____-т

Санал авах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалтад үндэслэн “Зөвлөх үйлчилгээ худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”-ийн төслийг шинэчлэн боловсруулж байна.

Зөвлөх үйлчилгээ худалдан авах тендерийн жишиг баримт бичгийн төсөлд холбогдох саналаа 2021 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн дотор ирүүлж хамтран ажиллахыг хүсье.

Жишиг баримт бичгийн төслийг www.mof.gov.mn, www.tender.gov.mn цахим хуудаснаас татан авна уу.

Холбоо барих: Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс, 267648, 267416, batzul_ts@mof.gov.mn, munkhtsetseg_g@mof.gov.mn.

Хавсралт: хуудас.



Б.ЖАВХЛАН

9762006071

ТАНИЛЦУУЛГА

Тендерийн жишиг баримт бичиг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.4.1-д “тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх” үйл ажиллагааг 2016-2023 онд хэрэгжүүлэх зорилт болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.” гэж заасныг удирдлага болгон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын Их Хурал 2019 онд баталсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд орсон 2019 оны нэмэлт, өөрчлөлт болон цахим системтэй уялдуулахтай холбогдуулж бодлогын баримт бичгийг бүхэлд нь шинэчлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж Төсвийн ерөнхийлөн захирагч нараас 2019 оны 11 дүгээр сар, 2020 оны 3 дугаар сар болон 7 дугаар сард санал авч тусган бодлогын баримт бичгийг боловсрууллаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд орсон өөрчлөлтүүдэд нийцүүлэн хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.3 дах заалтыг үндэслэн “Зөвлөх үйлчилгээ худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”-ийн төсөлд дараах өөрчлөлтийг тусгасан танилцуулж байна.

- Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ээр тендер шалгаруулалт зохион байгуулахтай холбоотой тендер оролцогч нарт тендер бэлтгэх, илгээх, тендер оролцохтой холбоотой зааварчилгааг шинэчлэн боловсруулсан.
- Захиалагчийн зүгээс нэг шалгуур үзүүлэлтийг давхардуулж шаарддаг асуудлыг хуулийн 14-16 дугаар зүйлтэй уялдуулан дэлгэрэнгүй жагсаалт үүсгэх зааварчилгаа, санал ирүүлэхэд баримтлах зааварчилгаатай нийцүүлэн өгөгдлийн хүснэгтийг боловсруулсан.
- Тендер шалгаруулалтыг гэрээний эрх зүйн харилцаанаас тусад нь салгаж гэрээнд зайлшгүй дагаж мөрдөх заалтыг санал ирүүлэхэд баримтлах зааварчилгаа болон өгөгдлийн хүснэгтэд тусгасан.

Тендерийн жишиг баримт бичгийг шинэчлэхэд худалдан авах ажиллагаа, төсөв, санхүүгийн салбар цахим шилжилт хийсэнтэй холбоотойгоор тендер шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.25 дахь заалтад заасан худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулах, тендер оролцогч өөрийн тендер болон захиалагчтай харилцах албан бичгийг Цахим гарын үсгийн тухай хуульд нийцүүлэн тоон гарын үсгээр баталгаажуулан илгээх, тендер шалгаруулалтад оролцохтой

холбоотойгоор бүрдүүлэх баримт бичгийн тоог цөөрүүлж, төрийн эрх бүхий байгууллагад байгаа мэдээллийг цахим системээр дамжуулан татан авч хянан үзэх, үнэлэх зэрэг шинэлэг зохицуулалтыг тусгах зорилтыг тавьсан.

Жишиг баримт бичиг дараах 6 бүлэгтэй.

Нэгдүгээр бүлэг нь захиалагч тендер шалгаруулалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилготой ба худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах болон тус цахим системээр тендер ирүүлэхэд баримтлах зааварчилгааг нарийвчлан тусгасан.

Хоёрдугаар бүлэгт захиалагч үйлчилгээний онцлогт нийцүүлэн шалгуур үзүүлэлтийг боловсруулахад дэмжлэг болох зорилгоор жишээ, зааварчилгаатай өгөгдлийн хүснэгтийг боловсруулсан.

Гуравдугаар бүлэгт захиалагчид зориулан гүйцэтгүүлэх үйлчилгээний онцлогт нийцүүлэн ажлын даалгаврын загвар, гүйцэтгэх үйлчилгээнд тавигдах шаардлагыг боловсруулах санамж оруулж өгсөн.

Дөрөвдүгээр бүлэгт зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох чанарын үнэлгээний арга, тендер шалгаруулалтын онцгой журмын гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх үед баримтлах Хэлэлцээр хийх зааврыг оруулсан.

Тавдугаар бүлэгт тендерт оролцогчийн бэлтгэх техникийн санал, санхүүгийн санал болон бусад жишиг маягтуудыг оруулж өгсөн. Энэхүү жишиг баримт бичгийн дагуу зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт цахим системээр зохион байгуулагдах тул уг жишиг маягтуудыг цахим системтэй уялдуулан шинэчлэн боловсруулсан.

Зургаадугаар бүлэгт гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягтуудыг тус тус тусгасан болно.

Шинэчилсэн жишиг баримт бичгийг захиалагч байгууллагын 2022 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу зөвлөх үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулахад дагаж мөрдөх бөгөөд уг хугацаанд бүх шатны захиалагч байгууллагыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллана.